

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНГОВЬ СУМЫН
“ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖ”-ИЙН ХУВЬ ХЭМЖЭЭГ
ШИНЭЧЛЭН ТОГТООСОН ТУХАЙ АКТАД ХИЙСЭН
НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2023 оны 07 дугаар сарын 07

Өргөн

Сумын төвийн өрхийн ахуйн болон энгийн хог хаягдлын хураамжийн сард төлөх хувь хэмжээг өөрчлөн тогтоох үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох нь:

Нэг. Тогтоол гаргах үндэслэл, зорилт:

1.1. “Хог хаягдлын тухай” хууль нь 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр УИХ-аар хэлэлцэн шинэчлэгдэн батлагдаж, хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж байна. Энэ хуулийн зорилт нь хог хаягдал сэргээн ашиглах хог хаягдлаар эрчим хүч үйлдвэрлэх, эсхүл нэрэх, цэвэрлэх, сэргээх зэрэг аргаар анхны хэлбэрт оруулж, ашиглах, хог хаягдал дахин боловсруулах, хог хаягдлыг шатаах, булшлах зохицуулалттай.

1.2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоох тухай Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаал 2018 оны 192 дугаар А/243 тоот / тушаалд:

1. Сум, дүүргийн ИТХ нь Хог хаягдлын тухай хуулийн 9.2.2-т заасны нутаг дэвсгэртээ мөрдөгдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтооно.

2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ гэж заасны дагуу хувь хэмжээг тогтоох хууль зүйн үндэслэл болж байна.

Хоёр. Шаардлага:

2.1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага нь хог хаягдлыг хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор хөнөөлгүй цуглуулж, тээвэрлэх, булшлах, мөн хог ачигч нарын цалин хөлс, нийгмийн баталгааг хангахад хүрэлцэхүйц биш байгаа учраас нэмэгдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд татварын орлогыг сумын төсөвт төвлөрүүлж, хог хаягдлын менежментийг сайжруулах тулгамдаж буй асуудалд зарцуулах шаардлагатай байна.

2.2. Орлогын эх үүсвэрийг хог хаягдлын менежментийг сайжруулах, хог ачигчдын нийгмийн баталгааг хангах зардалд зарцуулна.

Энэхүү эрх зүйн актыг сумын төвийн айл өрхүүд дагаж мөрдөнө.

Гурав. Асуудал нь ямар бүлгийн эрх, ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж байна вэ?

3.1. Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.7 дахь заалтад заасны дагуу Хог хаягдлын хураамжийн төлөгч этгээд"-ийн эрх ашигт нийцэж байна.

Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх зүйл байхгүй.

Дөрөв. Асуудлыг зохицуулж буй бусад хууль тогтоомж байгаа юу?


Татварын Ерөнхий хууль, Хог хаягдлын тухай хууль болон Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулагдана.

Тав. Шийдвэр гарснаар нийгэмд үзүүлэх үр нөлөө нь юу байж болох вэ? /Асуудал нь хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх/.

Хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй заалт байхгүй.

Зургаа. Хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо Татварын улсын байцаагч, Байгаль орчны хэсэг, сумын 1-5 дугаар багийн засаг дарга нар, төрийн сангийн мэргэжилтэн, хөдөө аж ахуй мэргэжилтэн.

ХЯНАСАН:
ДАРГА  Г.АМАРЖАРГАЛ

ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ТАТВАРЫН УЛСЫН
БАЙЦААГЧ  Н.БУЯНЖАРГАЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНГОВЬ СУМЫН
ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ХУВЬ ХЭМЖЭЭГ
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ ЗАХИРГААНЫ ХЭМ
ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛД ИРГЭДЭЭС САНАЛ АВСАН
ТУХАЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯВЦЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 07 дугаар сарын 07

Өргөн

Сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 08 тоот захирамжаар байгуулагдсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэн, хяналт тавьж ажиллах” ажлын хэсгийн бүрэлдэхүүн Хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдүүдэд зар мэдээллийг хүргэж, тэдний төлөөлөл болох 233 иргэнд 2023 оны 06 сарын 16-27-ний өдрүүдэд Хог хаягдлын хураамжийн тухай хуулийг суртачлан танилуулах нөлөөллийн арга хэмжээ болон, татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлаар санал авч хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгийг Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалтын дагуу “Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, санал асуулга авна” гэж заасны дагуу зохион байгуулсан.

Баянговь сумын төвийн өрхийн ахуйн болон энгийн хог хаягдлын хураамж төлөгч иргэд хамаарагдаж байгаа билээ.

Иргэдийн дунд зохион байгуулсан санал асуулгаар:

2023 оны 06 сарын 15-нд Хэлтгий булаг 1-р багийн ИНХ-д 35 малчин оролцож, сумын төвийн айл өрхийн хог хаягдлын хураамжийн хэмжээг өөрчлөх тухай санал асуулгад 7000 төгрөг байхаар 50 хувь дэмжив.

2023 оны сарын 06 сарын 27-нд Өрхт 2-р багийн ИНХ-д 59 малчин өрх оролцож, сумын төвийн айл өрхийн хог хаягдлын хураамжийн хэмжээг өөрчлөх тухай санал асуулгад 6000 төгрөг байхаар 50 хувь дэмжив.

2023 оны 06 сарын 16-нд Залаа 3-р багийн ИНХ-д 54 малчин оролцон санал асуулгад 6000 төгрөг байхаар 100% дэмжсэн.

2023 оны 06 сарын 19-нд Цоохор 4-р багийн ИНХ-д 45 малчин оролцон санал асуулгад 7000 төгрөг байхаар 100% дэмжсэн.

2023 оны 06 сарын 26-нд Өргөн 5-р багийн ИНХ-д 40 өрх оролцон санал асуулгад 7000 төгрөг байхаар 100% дэмжсэн.


Хог хаягдлын хураамжийн хувь хэмжээний санал асуулгын дүнг нэгтгэхэд хэлэлцүүлэгт оролцогч иргэдийн 79,1% нь 7000 төгрөг байвал зохистой гэж үзсэн

бол 20,9% нь 6000 төгрөг байвал зохиостой гэж үзсэн байна. Иймд Хог хаягдлын хураамж нь 7000 төгрөг байхаар санал нэгтгэгдэн шийдвэрлэгдсэн.

Хэлэлцүүлэгт оролцсон иргэд Хог хаягдлын хураамжийн хувь хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж, санал асуулгад идэвхтэй хамрагдсан.

Хог хаягдлын тухай хуулийг иргэд олон нийтэд суртачлан таниулах, хэрэгжилтэд хяналт тавьж байх, хог хаягдлын менежментийг сайжруулах талаар оролцогчдоос зөвлөсөн.

ХЯНАСАН:
ДАРГА  Т.АМАРЖАРГАЛ

ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:
ТАТВАРЫН УЛСЫН
БАЙЦААГЧ  Т.БУЯНЖАРГАЛ